

Сумын Засаг даргын 2021 оны
..... -р сарын -ны өдрийн
..... тоот албан бичгийн хавсралт

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2021.12.25-2021.01.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/211 дугаар захирамжаар “2020 оны жилийн эцсийн хүн ам, мал тэжээвэр амьтдын тооллого”-ын ажлыг зохион байгуулах комисс 24 хүний бүрэлдэхүүнтэй томилогдож, комиссын гишүүддээ хүн ам, мал тооллогын сургалт зохион байгуулж, урьдчилсан байдлаар адуу-2234, үхэр-2744, тэмээ-181, хонь-26476, ямаа-27591 нийт 59226 толгой мал тоологдож, 1042 өрхийн 3765 хүн ам, тоологдоод байна.

Шивээговь сумын Засаг дарга, аймгийн Улаан загалмайн хороо, сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран хөдөөгийн малчин өрхүүдийн өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж тэдэнд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцон, цэцэрлэгийн болон сургуулийн насны хүүхдүүдэд сургалтын материал, хичээлийн хэрэгсэл, улаан загалмайн хорооноос хүнсний болон ахуйн хэрэглэл, дулаан гутал хувцас олголоо. Мөн Эрүүл мэндийн төвөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийж, эмийн сангийн үйлчилгээ үзүүлсэн. Малчдын санал хүсэлтийг сонсоход өвөлжөө, хаваржааны газар, отор нүүдэл, өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан өвс тэжээл, түлээ нүүрсний дутагдалд орж байгаа талаар хэлж байна. Иймд аймгийн аюулгүйн нөөцөөс 1000 боодол өвс татаж хямдралтай үнээр 108 өрхөд 750 гаруй боодол өвс олгоод байна. Мөн ШОХК-иас гал алдах байдалтай малчин өрхүүдэд 30 тн нүүрсийг 30 өрхөд олгосон.




Суманд 2 пост ажиллаж байснаас 2-р постны үйл ажиллагааг 2021 оны 01-р сарын 11-нд зогсоож, одоогоор засмал замын 1-р пост ажиллаж ачаалал эрс нэмэгдсэн. Постонд ажиллаж байгаа албан хаагчдад сумын онцгой комиссоос өдрийн 3 хоол, цай олгож байна.

Сумын шуурхай штабаас Улаанбаатар хот болон өөр аймаг орон нутаг руу зорчих зөвшөөрлийг зөвшөөрөгдсөн 4 шалтгаанаар 68 иргэнд олгоод байна.


Сумруу ирэх хүсэлт гаргасан 13 иргэнийг татан авсанаар 2021 оны 1-р сарын 25-ны өдрийн байдлаар гэрийн тусгаарлалтанд 48 иргэн байна. Сумаас зорчих хүсэлт гаргасан 23 иргэн бүртгүүлээд байна.

ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2020 оны жилийн эцсийн орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 93813200 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэл 108769067 мянган төгрөг төвлөрч 116 хувийн биелэлттэй ажилласан байна.



Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 116177300 төгрөгийг төвлөрүүлэхээс 104131418,78 сая төгрөгийг төвлөрүүлсэнээр төлөвлөгөөний хэрэгжилт 89,6 хувийн гүйцэтгэлтэй байна.



ДЭД БҮТЭЦ

Илчлэг-Шивээ ОНӨҮГ-ын халаалтын зуухны барбан, экран хоолой хагарч 2021 оны 01-р сарын 16-18-ны өдрүүдэд аймгийн Ус-Ду ОНӨҮГ-тай хамтран засварлаж ашиглалтанд оруулсан. Мөн гэр хорооллын 2 худаг хөлдсөн тул хэсгээж хэвийн үйл ажиллагаанд оруулсан. Нүүрс 3 хоногийн нөөцтэй байна. Өнөөдрийн байдлаар

температур 64 градустай байна. Илчлэг-Шивээ ОНӨҮГ нь нийт 14 галч ажиллахаас өнөөдрийн бадлаар 7 галч ажиллаж, 7 галч ажлаа хаяж явсан байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2020 оны жилийн эцсийн мэдээг гаргаж ТЗУХ-т хүргүүлсэн. Үүнд:

2020 онд Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт нийт 370 өргөдөл хүлээн авч 368 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийн явц 99,5%-тай байна.

Сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан сумын ИТХ-ын хуралдааны 08 дугаар тогтоолоор батлуулсан.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ :

2020-2021 оны хичээлийн жилийн 1 дүгээр хагас жилийн улирлын дүнгийн үнэлгээ гаргаж суралцагчдад танилцуулсан.


Сургуулийн дотуур байрны сантехникийн сэлбэгийг Улаанбаатар хотоос авчирч засварын ажлыг эхлүүлээд байна.



ЭЕШ-ын хичээлүүдээр мэргэжлийн шинжээч багш нар 01-р сарын 13, 14-ний өдрүүдэд UBL meet-ээр 2020 оны хичээлүүдийн даалгаврын сэдэв дээр анализ хийж алдаан дээрээ ажиллах хэлэлцүүлэг хийлээ.

Хүүхдийн амралтын үеэр явагдсан сонгонтод давтлаганд монгол хэл, математикийн 2 багш хичээл зааж 45-50 суралцагч тогтмол хичээллэж байна.

Цахим болон танхимын сургалт, зайн сургалтыг явуулах туршлагаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор багш нарын илтгэлийн уралдааныг цахимаар зохион байгуулж 36 багш оролцосноос 1-3-р байрыг шалгаруулсан. Эхний 2 байранд орсон илтгэл аймгийн багш нарын илтгэлийн уралдаанд оролцож байна.



Цэцэрлэгийн багш бүр теле хичээл үзүүлэх болон цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гарын авлага ном тараах, өөрсдийн бэлтгэсэн хичээлийг бүлэг бүрийн групп хуудасаар дамжуулан хүргэж байгаа нь нийт хүүхдийн 85.4 %-ийг хамруулаад байна.

Цэцэрлэгийн нийт эцэг эхчүүдийн дунд 3-р цэцэрлэгийн 2020-2021 оны үйл ажиллагааны хөндлөнгийн үнэлгээг онлайнаар авсан бөгөөд 180 гаруй эцэг эх буюу 61%-ийг хамруулсан байна. Цэцэрлэгийн үйл ажиллагааг 75.2% нь маш сайн , 24.2% нь дунд, 0.6% нь хангалтгүй гэж үнэлсэн байна.

д/д	Бүлэг	Бүлгийн хүүхдийн хүүхдийн тоо	Теле хичээл үзэх хүүхдийн тоо	Багштай харилцаж теле хичээл үзэж байгаа хүүхдийн тоо	Өдрийн дундаж ирц	Хувь
1	Бага бүлэг	26	26	21	21	79%

2	Дунд бүлэг	98	98	86	86	87,7%
3	Ахлах бүлэг	86	86	74	74	86,0
4	Бэлтгэл бүлэг	78	78	65	65	83,3
Цэцэрлэгийн дүн		288	288	246	246	85,4%

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 9 өвчтөн хэвтэж үүнээс 1 хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнс, эм тарианы хангалт хүрэлцээтэй байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг -314
- Урьдчилан сэргийлэх –70
- Дуудлага-61

Эрүүл мэндийн даатгалын 2020 оны гэрээг 01-р сарын 10-ны өдөр дүгнүүлж 89%-тай үнэлэгдсэн байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Коронавирусийн үед ажиллах бэлэн байдлыг хангах 6 өдрийн цахим сургалтанд албан хаагчдыг бүрэн хамруулсан. Мөн аймгийн нэгдсэн эмнэлгээс 01 сарын 18-ны өдөр зохион байгуулсан COVID-19 халдварын үед ажиллах бэлэн байдлын сургалт, дадлагад байгууллагын 16 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид хамрагдсан. Сумын Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилчид хамгаалах хувцас өмсөх, тайлах дарааллаар өдөр бүр тогтмол дадлага сургуулилтыг хийж байна.



Сумын Эрүүл мэндийн төвийн жишиг шүдний кабинетийг тохижуулах ажилд манай сум сонгогдон хуучин эмнэлгийн зүүн талын хэсэгт засварын ажил хийж байна. Тус ажилтай аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга нар танилцан тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлээд байна.

Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, мэргэжилтэн, сумын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газрын байцаагч нар сумын эрүүл мэндийн төвийн COVID-19-н үед ажиллах бэлэн байдлыг шалган дадлага, сургуулилт хийсэн.



Эрүүл мэндийн төвд сэгжигтэй тохиолдол илэрсэн үед тусгаарлах, ажиглах байр, шинжилгээний түр цэг, амьсгалын замын халдвартай үйлчлүүлэгчийн үзлэгийн өрөөг эрүүл мэндийн сайдын тушаал түр зааварын дагуу сайжруулан бэлтгээд байна.



МАЛ ЭМНЭЛЭГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ

Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын даргын удирдамжийн дагуу цагдаагийн хэсэгтэй хамтран 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр сумын худалдаа, үйлчилгээний газруудад хууль тогтоомжийн биелэлт, ажлын байрны дүгнэлт, ариутгал халдваргүйтэл, худалдаалагдаж байгаа хүнсний бүтээгдэхүүний хугацаа, хадгалалтын горим хэвийн эсэх, Ковид 19-тэй холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа зэрэгт хяналт тавин заавар зөвлөмжийг хүргэн ажиллалаа.



Суманд отроор 24 малчин өрхийн 444 бод, 15171 бог нийт 15615 толгой мал өвөлжиж байна.

Шивээговь сумын том малын зүй бус хорогдол нийт 603 үүнээс адуу-5, үхэр-2, хонь-236, ямаа-400 байна.

Шивээговь сумын хүнсний нөөцийн судалгааг нийт 9 дэлгүүр, 1 махны лангуу, 1 усны үйлдвэрээс өдөр бүр авч нэгтгэн аймгийн ХААГ-т болон сумын шуурхай штабт гарган өгч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын арьс, шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан 29 малчин, мал бүхий иргэдийн 91ш падан болох үхэрийн шир 83ш, хонины нэхий 2955 ш, ямааны арьс 3168 ш нийт 6206 ш арьс ширний баримтыг программд шивж оруулсан.

Шивээговь сумаас нийт Шивээговь сумын өвсний фондод байгаа харлаж муудсан өвсний дээжийг 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид шинжилүүлж, шинжилгээний хариу малд өгч болохгүй гэсэн 20-3584 бүртгэлийн дугаартай дүгнэлтийн дагуу Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар тушаалаар “Өвс акталж, устгалд оруулах” ажлын хэсэг томилогдон 383 боодол өвсийг устгалд оруулсан.



НИЙГМИЙН БОДЛОГО

Аймгаас зохион байгуулсан "Угийн бичгээ хөтөлж, Ураг удмаа хамгаалъя" уралдаанд Шивээговь сум маань амжилттай оролцож Тэргүүн байр эзэллээ. Уг уралдаанд тэргүүн байр эзлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан М. Хишигдэлгэр, Ж.Сүнжидмаа, Б.Энхцэцэг, С.Нас-Урт, Г.Амарсайхан нарыг сумын Засаг дарга хүндэтгэн хүлээн авч талархал илэрхийлж дурсамж мөнгөн шагналаар урамшууллаа.

Мөн "Үндэсний Үсэглэлийн Аварга " шоу нэвтрүүлэгт оролцож 2000 гаруй хүүхдээс гуравт үлдэж сум орон нутаг, сургуулийнхаа нэрийг үндэсний хэмжээнд гаргасан Шивээговь сумын 3-р сургуулийн 6б ангийн сурагч Э. Буянхишигийг Засаг дарга хүлээн авч баяр хүргэн гарын бэлэг гардууллаа.



БАЙГАЛЬ ОРЧИН

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хэмжээнд зохион байгуулж тайланг УЦУОШГ-т хүргүүлсэн.

Аймгийн БОАЖГ-тай хамтран Чойр ууланд биотехникын арга хэмжээ авах ажилд оролцож Чойр ууланд амьдардаг ан амьтанд өвс, хужир тавьж өгсөн.

Сумын төв хогийн цэгийн орох, гарах гарцыг нээх, туурь хогийг цэвэрлэх ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж 1 га талбайн 40 тн ахуйн болон барилгын хог хаягдлыг Эрүүл ахуй орчны бохирдолыг бууруулах - Хоггүй сум дэд хөтөлбөрийн 1 сая төгрөгийн зардлаар цэвэрлүүлэн булж тэгшилсэн.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сумын 2021 оны ОНХС-ийн 306 510 900 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэх 21 арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан Tender.gov.mn, шилэн данс, сангийн яамны сайт, shiveegov.gov.mn зэрэг цахим хуудаст байршуулан иргэдэд мэдээллэн ажиллаж байна.

Суманд цэвэрлэх байгууламж барих ажлын зураг төсөв магадлалын дүгнэлт гаргуулах шатандаа явагдаж байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА